



ҮНДЭСНИЙ АУДИТЫН  
ГАЗРЫН ХАРЬЯА  
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032-3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ҮНЭН БА ЗӨВ НАМ-Д

2020.07.22. № 185.

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хандивын тайлангийн дүгнэлт**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Үнэн ба Зөв намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Үнэн ба Зөв нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Тухайн намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулаагүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Үнэн ба Зөв намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.


## Дүгнэлт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ҮНЭН БА ЗӨВ НАМ** нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

“Өвөрхангай аймгийн Үнэн ба Зөв нам”-аас ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт..... хуудастай.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж,  
дүгнэлт гаргах зааврын хавсралт

МАЯГТ-1

Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох  
нам, эвсэлд "ИРГЭН"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

*Чимэг Лавнам* /намын нэр/

*Өвөрхангай аймгийн намун хороо байгуулагдаад үдсэний дэмжлэгээр дамжаж байна.*

Иргэний овог нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл				Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		Тайлбар
	Регистрийн дугаар	Нас	Оршин суугаа хаяг	Утасны дугаар			Банкны нэр	Дансны дугаар	
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон									
Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд									

ИЖ: Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан иргэн, хуулийн эзэс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.



Тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдгээр баталгаажуулна.

*Чимэг Лавнам* /намын нэр/ *Чимэг Лавнам* /намын нэр/ *Чимэг Лавнам* /намын нэр/

албан тушаал овог нэр гарын үсэг

*2020.06.24*

Огноо

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж,  
дүгнэлт гаргах зааврын хавсралт

МАЯГТ-2

Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд оролцох  
нам, эвсэлд "ХУУЛИЙН ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

*Овоглогчийн аймгийн Увс Бя Зов нам* Инамын нэр/  
*намын нэрээр байгуулагдсан үүрэгч болоод элср нь дунд хотын нам*

Хуулийн этгээдийн нэр	Хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээлэл					Хандив хүлээн авсан			Мөнгөн дүн	Тайлбар
	Регистрийн дугаар	Хаяг, утасны дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажиллагааны чиглэл	Хуулийн этгээдийн хэлбэр	Огноо	Банкны нэр	Дансны дугаар		
Ээлжит сонгуулийн жилийн өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон										
Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд										

Инамж: Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан ирээн, хуулийн  
тгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.



Тамга, тэмдэг

Тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдгээр баталгаажуулна.

Албан тушаал

овог нэр

гарын үсэг

2020.06.24

Огноо